



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 283

Улаанбаатар хот

Журамд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын "Журам батлах тухай" 2013 оны 322 дугаар тогтоол, "Үзүүлэлт батлах тухай" 2014 оны 68 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Журам шинэчлэн батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2013 оны 448 дугаар тушаалын долоодугаар хавсралтын "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын нийтлэг үзүүлэлт"-д нэмэх шалгуур үзүүлэлтийг нэгдүгээр, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Геронтологийн үндэсний төв, Хүүхдийн төв сувилал, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын өвөрмөц үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг харъяа эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, ерөнхий захирал нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /С.Төгсдэлгэр/-д даалгасугай.

САЙД



Н.УДВАЛ